1.2	Adjustments of gain or loss:	-222,523,751.60	-125,361,054.32
1.2.1	Impairment loss (+)	1,521,141.77	1,082,404.44
1.2.2	Depreciation and amortization expense (+)	21,028,653.89	11,697,724.03
1.2.3	Revaluation gain (-) or losses (+) on financial instruments excluding cash and cash equivalents	0.00	0.00
1.2.4	Accrued interest income (-)	-500,599,538.83	-308,332,220.06
1.2.5	Accrued interest expense (+)	256,526,566.48	170,150,461.06
1.2.6	Gains (-) or losses (+) on disposal of assets	-1,000,574.91	40,576.21
1.2.7	Other gains (-) or losses (+)	0.00	0.00
1.3	Adjustments of changes in assets and liabilities:	559,745,142.25	-214,825,419.22
1.3.1	Increase (-) or decrease (+) in due to banks and financial institutions	-81,957,724.30	-8,924,410.06
1.3.2	Increase (-) or decrease (+) in trading securities	-9,954,204.67	495,244,086.83
1.3.3	Increase (-) or decrease (+) in loans	-360,735,034.03	-750,404,567.892
1.3.4	Increase (-) or decrease (+) in other financial assets	20,116,410.18	-1,310,792.42
1.3.5	Increase (-) or decrease (+) in other non-financial assets	-37,597,652.48	32,570,128.80
1.3.6	Increase (+) or decrease (-) in current accounts and savings accounts	694,623,853.38	638,467,201.60
1.3.7	Increase (+) or decrease (-) in due to banks and financial institutions	166,147,467.83	6,386,952.03
1.3.8	Increase (+) or decrease (-) in other financial liabilities	136,963,487.07	-647,956,228.47
1.3.9	Increase (+) or decrease (-) in other non-financial liabilities	32,138,539.26	21,102,210.36
1.4	Other adjustments:	174,473,972.24	98,516,162.90
1.4.1	Interest received (+)	482,678,184.18	297,395,713.93
1.4.2	Interest paid (-)	-279,357,683.09	-184,709,649.01
1.4.3	Payment of income tax (-)	-28,818,741.81	-14,169,902.02
1.4.4	Written-off loan and receivables with loan loss provision (-)	-27,787.03	0.00
1.4.5	Accounting changes	0.00	0.00
1.5	Net cash flows from operating activities	635,283,207.54	-182,717,633.36
<b>2</b>	<b>Cash flows from investing activities:</b>	***	***
2.1	Total cash inflows (+)	10,577,500,795.00	113,104,807.76
2.1.1	Proceeds from disposal of PPE	39,601.00	0.00
2.1.2	Proceeds from disposal of intangible assets	0.00	0.00
2.1.3	Proceeds from disposal of investment properties	10,658,874.00	0.00
2.1.4	Proceeds from disposal of investment in subsidiary, associate, and joint venture	0.00	0.00
2.1.5	Proceeds from disposal of other non-current assets	10,566,802,320.00	0.00
2.1.6	Proceeds from disposal of securities classified as loan and receivables	0.00	0.00
2.1.7	Proceeds from disposal of securities available for sale	0.00	113,104,727.73
2.1.8	Proceeds from disposal of securities held to maturity	0.00	0.00
2.1.9	Dividend received	0.00	80.04
2.1.10	Other proceeds	0.00	0.00
2.2	Total cash outflows (-)	-10,837,638,086.00	-107,689,889.17
2.2.1	Acquisition of PPE	30,301,330.00	16,432,988.49
2.2.2	Acquisition of intangible assets	3,190,930.00	654,900.67
2.2.3	Acquisition of investment properties	10,804,145,826.00	0.00
2.2.4	Acquisition of investment in subsidiary, associate, and joint venture	0.00	0.00
2.2.5	Acquisition of securities classified as loan and receivables	0.00	90,000,000.00
2.2.6	Acquisition of securities available for sale	0.00	602,000.00
2.2.7	Acquisition of securities held to maturity	0.00	0.00
2.2.8	Acquisition of other non-current assets	0.00	0.00
2.2.9	Other outflows	0.00	0.00
2.3	Net cash flows from investing activities	-260,137,291.00	5,414,918.60
<b>3</b>	<b>Cash flows from financing activities:</b>	***	***
3.1	Total cash inflows (+)	510,332,167.33	164,658,043.57
3.1.1	Repayment of other borrowed funds	510,332,167.33	164,658,043.57
3.1.2	Proceeds from subordinated debt	0.00	0.00
3.1.3	Proceeds from issuance of shares	0.00	0.00
3.1.4	Donation	0.00	0.00
3.1.5	Other	0.00	0.00
3.2	Total cash outflows (-)	-444,705,191.27	-62,146,424.15
3.2.1	Repayment of other borrowed funds	392,885,768.07	12,123,152.40
3.2.2	Repayment of subordinated debt	0.00	0.00
3.2.3	Finance lease payment	3,734,894.00	0.00
3.2.4	Repurchase of treasury shares	0.00	0.00
3.2.5	Dividends paid	48,084,529.20	49,987,371.75
3.2.6	Other	0.00	35,900.00
3.3	Net cash flows from financing activities	65,626,976.06	102,511,619.42
4	Effect of exchange rate changes on cash and cash equivalents	0.00	0.00
5	Net cash flows	440,772,892.60	-74,791,095.34
6	Cash and cash equivalents at the beginning of the period	1,156,312,729.63	1,597,085,622.23
7	Cash and cash equivalents at the end of the period	1,597,085,622.23	1,522,294,526.88

First deputy CEO

Director of Finance Department

Accounting and monitoring specialist of Finance Department

Director of Financial Reporting Division

Monitoring specialist of Financial Reporting Division

Reporting specialist of Financial Reporting Division

Sugar D.

Gantuya M.

Batbaatar Sh.

Lkhagvasuren D.

Narantsatsral D.

Jargalmaa D.





## STATEMENT OF OTHER COMPREHENSIVE INCOME

/in MNT'000/

STATE BANK		2023/12/31	2024/06/30
	Items of income and expense	Prior period amount	Current period amount
<b>1</b>	<b>Interest income</b>	<b>500,599,538.83</b>	<b>308,332,220.06</b>
1.1	Interest income of due from the Bank of Mongolia	18,620,095.44	8,571,256.05
1.2	Interest income of due from other banks and financial institutions	9,675,768.54	1,513,565.42
1.3	Interest income of investment	107,559,201.04	68,632,313.26
1.4	Interest income of loan	352,292,610.48	219,485,765.97
1.5	Other interest income	12,451,863.34	10,129,319.36
<b>2</b>	<b>Interest expense</b>	<b>256,526,566.48</b>	<b>170,150,461.06</b>
2.1	Interest expense of current accounts	10,095,750.30	8,585,687.80
2.2	Interest expense of savings	203,142,364.93	124,411,241.61
2.3	Interest expense of borrowings	11,512,810.79	13,523,419.30
2.4	Interest expense of debt instruments	9,822,728.98	5,042,049.94
2.5	Other interest expense	21,952,911.49	18,588,062.41
<b>3</b>	<b>Net interest income/expense [(1)-(2)]</b>	<b>244,072,972.35</b>	<b>138,181,759.00</b>
<b>4</b>	<b>Impairment loss on</b>	<b>40,701.86</b>	<b>252,102.91</b>
4.1	Due from banks and financial institutions	40,701.86	-
4.2	Investment	0.00	252,102.91
4.3	Loans	0.00	-
<b>5</b>	<b>Net income after impairment loss [(3)-(4)]</b>	<b>244,032,270.49</b>	<b>137,929,656.09</b>
<b>6</b>	<b>Other revenue</b>	<b>69,256,831.19</b>	<b>36,694,202.25</b>
6.1	<i>Non-interest income</i>	57,361,743.87	27,711,762.45
6.1.1	Gain or (loss) on trading of financial instruments	17,413,277.42	2,813,934.56
6.1.2	Gain or (loss) on translation or revaluation of financial instruments	0.00	1,716,673.31
6.1.3	Income from service fee and charges	39,782,976.93	23,121,775.86
6.1.4	Other non-interest income	165,489.52	59,378.72
6.2	<i>Other income and gains</i>	11,895,087.32	8,982,439.80
<b>7</b>	<b>Other expense</b>	<b>189,701,257.04</b>	<b>115,671,181.05</b>
7.1	<i>Non-interest expense</i>	189,101,511.20	115,426,538.35
7.1.1	Other impairment loss	1,480,439.91	830,301.53
7.1.2	Gain or (loss) on trading	0.00	-
7.1.3	Gain or (loss) on translation or revaluation	13,457,550.95	8,380,091.35
7.1.4	Expenses of service fee and charges	11,437,503.14	7,153,161.42
7.1.5	Other operating expenses	162,726,017.21	99,062,984.05
7.2	<i>Other expense and loss</i>	599,745.85	244,642.70
<b>8</b>	<b>Profit or (loss) before tax (5+6-7)</b>	<b>123,587,844.64</b>	<b>58,952,677.28</b>
9	Income tax expense	28,818,741.81	14,169,902.02
<b>10</b>	<b>Profit or (loss) after tax (8-9)</b>	<b>94,769,102.83</b>	<b>44,782,775.27</b>
11	Net profit or (loss) after tax from discontinued activities	0.00	-
<b>12</b>	<b>Profit or (loss) for the reporting period (10+11)</b>	<b>94,769,102.83</b>	<b>44,782,775.27</b>
13	Other comprehensive income	32,456,159.05	(1,958,373.52)
13.1	Increase or decrease of revaluation surplus of PPE and intangible assets	19,788,654.32	-
13.2	Increase or decrease of Reserve for revaluation of available for sale securities	12,700,061.34	(1,922,473.52)
13.3	Increase or decrease of reserve of translation and revaluation	0.00	-
13.4	Increase or decrease of non-distributable regulatory reserve for BOM loan loss provisions	0.00	-
13.5	Other	(32,556.61)	(35,900.00)
<b>14</b>	<b>Profit or (loss) for the reporting period (10+11)</b>	<b>127,225,261.88</b>	<b>42,824,401.74</b>

First deputy CEO

ТӨРИЙН  
БАНК

Director of Finance Department

Accounting and monitoring specialist of Finance Department

Director of Financial Reporting Division

Monitoring specialist of Financial Reporting Division

Reporting specialist of Financial Reporting Division

Sugar D.

Gantuya M.

Batbaatar Sh.

Lkhagvasuren D.

Narantsatsral D.

Jargalmaa D.



## STATEMENT OF CHANGES IN EQUITY

/in MNT'000/  
6/30/2024

## STATE BANK

	Equity items	Share capital	Share premium	Treasury share	Revaluation reserve	Other components of equity	Retained earnings	Total equity
1	At 1 January 2023	188,774,062.5	14,652,725.0	0.0	22,586,672.6	(8,370,893.9)	278,566,613.0	496,209,179.1
2	Adjustment of changes in accounting policies and error	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-
3	Adjusted balance	188,774,062.5	14,652,725.0	0.0	22,586,672.6	(8,370,893.9)	278,566,613.0	496,209,179.1
4	Net profit or loss for the period	0.0	0.0	0.0	0.0	0.0	94,769,102.8	94,769,102.8
5	Other comprehensive income	0.0	0.0	0.0	22,018,518.4	12,667,504.7	0.0	34,686,023.2
6	Share issued	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-
7	Distributed dividends	0.0	0.0	0.0	0.0	0.0	(48,084,529.2)	(48,084,529.2)
8	Realized amount of revaluation surplus	0.0	0.0	0.0	(2,229,864.1)	0.0	0.0	(2,229,864.1)
9	At 31 December 2023	188,774,062.5	14,652,725.0	0.0	42,375,326.9	4,296,610.8	325,251,186.6	575,349,911.8
10	Adjustment of changes in accounting policies and error	0.0	0.0	0.0	0.0	20,150,706.1	(20,150,706.1)	-
11	Adjusted balance	188,774,062.5	14,652,725.0	0.0	42,375,326.9	24,447,316.9	305,100,480.5	575,349,911.8
12	Profit for the year	0.0	0.0	0.0	0.0	0.0	44,782,775.3	44,782,775.3
13	Other comprehensive income	0.0	0.0	0.0	0.0	(1,958,373.5)	0.0	(1,958,373.5)
14	Changes in equity	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-
15	Distributed dividends	0.0	0.0	0.0	0.0	0.0	(49,987,371.8)	(49,987,371.8)
16	Realized amount of revaluation surplus	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-
17	At 30 June 2024	188,774,062.5	14,652,725.0	0.0	42,375,326.9	22,488,943.4	299,895,884.0	568,186,941.8

First deputy CEO

Director of Finance Department

Accounting and monitoring specialist of Finance Department

Director of Financial Reporting Division

Monitoring specialist of Financial Reporting Division

Reporting specialist of Financial Reporting Division

Sugar D.

Gantuya M.

Batbaatar Sh.

Lkhagvasuren D.

Narantsaisral D.

Jargalmaа D.



1. 2. 3. 4. 5.



ТӨРИЙН БАНКНЫ ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНСНЫ ҮЛДЭГДЛИЙН ТАЙЛАН

2024 оны 06 дугаар сарын 30

Дансны код	Дансны нэр	Төгрөгөөр
	Тэнцлийн гадуурх дансууд	9,411,036,564,085.2
61000000	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамраарх үүрэг	24,709,543,368.8
61010000	Банкны гаргасан баталгаа	-
61020000	Импортын баталгаа	-
61030000	Экспортын баталгаа	-
61040000	Урьдчилгаа талборилги баталгаа	3,461,545,847.9
61050000	Банкны гаргасан батлан даалт	-
61060000	Векселлийн батлан даалт	-
61070000	Харилцагчийн өмнөөс гаргасан аккредитивын батлан даалт	-
61080000	Төцлөрийн батлан даалт	-
61090000	Гүйцэтгэлийн батлан даалт	1,950,843,145.5
61100000	Импортын аккредитив	9,914,395,655.5
61110000	Экспортын аккредитив	167,008,012.9
61120000	Зээлийн шугам	-
61130000	Овердрафтын зээлийн шугам	3,059,761,144.1
61140000	Хувиартай зээлтэй холбоотой хүлээж болзошгүй үүрэг	6,155,989,561.9
61150000	Үйл ажиллагааны түрээсээр хүлээсэн үүрэг	-
61160000	Халтын эзэлжүүлэлтээр хүлээсэн үүрэг	-
61170000	Бусад болзошгүй үүрэг	-
62000000	Барьцаа хөрөнгө	7,992,980,434,710.5
62010000	Үнэт цаас	-
62020000	Хөдөлх хөрөнгө	237,102,830,192.7
62030000	Үл хөдлөх хөрөнгө	3,235,639,131,818.0
62040000	Үнэт металл	-
62050000	Бусад аясан баталгаа, батлан даалт	142,675,645,972.5
62060000	Бусад барьцаа	4,377,562,826,727.3
63000000	Тэнцлээс хаасан хөрөнгө	93,956,229,963.1
63100000	Банк, санхүүгийн байгууллагууд байршуулсан хөрөнгө	-
63200000	Үнэт цаасны эрсдэлийн сангаар хаасан үнэт цаас	-
63300000	Зээлийн эрсдэлийн сангаар хаасан зээл	1,042,022,916.4
63400000	Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангаар хаасан хөрөнгө	-
63500000	Үнэт металлын эрсдэлийн сангаар хаасан үнэт металл	-
63600000	Аллагын эрсдэлийн сангаар хаасан аялага	78,517,248.9
63700000	Хуримтуулж тооцож зогсоосон хүү	92,834,689,797.8
64000000	Дериватив санхүүгийн хэрэгсэл	586,527,693,295.3
64100000	Своп арилжаа	6,773,083,450.0
64101000	Гадаад валютын арилжааны аялага	3,392,033,450.0
64102000	Гадаад валютын арилжааны оглог	3,381,050,000.0
64103000	Үнэт металлын арилжааны аялага	-
64104000	Үнэт металлын арилжааны оглог	-
64105000	Үнэт цаасны арилжааны аялага	-
64106000	Үнэт цаасны арилжааны оглог	-
64200000	Форвард	-
64201000	Гадаад валютын арилжааны аялага	-
64202000	Гадаад валютын арилжааны оглог	-
64203000	Үнэт металлын арилжааны аялага	-
64204000	Үнэт металлын арилжааны оглог	-
64205000	Үнэт цаасны арилжааны аялага	-
64206000	Үнэт цаасны арилжааны оглог	-
64300000	Своп	578,676,700,000.0
64301000	Гадаад валютын арилжааны аялага	287,389,250,000.0
64302000	Гадаад валютын арилжааны оглог	291,287,450,000.0
64303000	Үнэт металлын арилжааны аялага	-
64304000	Үнэт металлын арилжааны оглог	-
64305000	Үнэт цаасны арилжааны аялага	-
64306000	Үнэт цаасны арилжааны оглог	-
64307000	Тогтмол хүүгийн түвшиний своп	-
64308000	Хөлөгч хүүгийн түвшиний своп	-
64309000	Индекс	-
64310000	Бусад	-
64400000	Опцион	1,077,909,845.3
64401000	Гадаад валютын арилжааны аялага	557,964,639.8
64402000	Гадаад валютын арилжааны оглог	519,945,205.5
64403000	Үнэт металлын арилжааны аялага	-
64404000	Үнэт металлын арилжааны оглог	-
64405000	Үнэт цаасны арилжааны аялага	-
64406000	Үнэт цаасны арилжааны оглог	-
64407000	Бард, бүтээгдэхүүний арилжааны аялага	-
64408000	Бард, бүтээгдэхүүний арилжааны оглог	-
64500000	Фьючерс	-
64501000	Гадаад валютын арилжааны аялага	-

64502000	Галдвал валютын арилжааны өглөг	
64503000	Үнэт металлын арилжааны авлага	
64504000	Үнэт металлын арилжааны өглөг	
64505000	Үнэт цаасны арилжааны авлага	
64506000	Үнэт цаасны арилжааны өглөг	
64507000	Бараа, бүтээгдэхүүний арилжааны авлага	
64508000	Бараа, бүтээгдэхүүний арилжааны өглөг	
64600000	Бусад арилжааны	
64601000	Галдвал валютын арилжааны авлага	
64602000	Галдвал валютын арилжааны өглөг	
64603000	Үнэт металлын арилжааны авлага	
64604000	Үнэт металлын арилжааны өглөг	
64605000	Үнэт цаасны арилжааны авлага	
64606000	Үнэт цаасны арилжааны өглөг	
64607000	Бараа, бүтээгдэхүүний арилжааны авлага	
64608000	Бараа, бүтээгдэхүүний арилжааны өглөг	
64700000	Хэрэгжээгүй өргөс, зардлын нэгэр бүл	
65000000	Харилцагчийн эзэмтэй батлан даасан хөрөнгө	
65100000	Иван цаасны хадгалалт (инвентар)	
65110000	Компанийн хувьцаа, нэрлэсэн үнээрээ	
65120000	Компанийн бонд, нэрлэсэн үнээрээ	
65130000	Компанийн вексел, нэрлэсэн үнээрээ	
65140000	Эрүүдэл хуудлах буюу худалдан авах нөхцлөөр авсан үнэт цаас	
65150000	Засгийн газрын бонд, нэрлэсэн үнээрээ	
65160000	Орон нутгийн бонд, нэрлэсэн үнээрээ	
65170000	Засгийн газрын үнэт цаас, нэрлэсэн үнээрээ	
65180000	Бусад зүйлс, нэрлэсэн үнээрээ	
65200000	Бусад хөрөнгө	
66000000	Барьцааны тавьсан хөрөнгө	178,265,861,250.0
66010000	Мөнгөн хөрөнгө ба бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан халгалалт	
66020000	Үнэт цаас	178,265,861,250.0
66030000	Алианс	
66040000	Эзэл	
66050000	Хөрөнгө оруулалтын хөрөнгийн үл хөдлөх хөрөнгө	
66060000	Барилга, байгуулалт	
66070000	Үнэт металл	
66080000	Бусад хөрөнгө	
67000000	Тэнгэрийн газуур бусад дингууд	534,597,801,497.5
67010000	Галдвал худалданы санхүүжилтэнд зориулсан гадаргын банкуудад нээсэн шугам	
67020000	Галдвалын банкуудад нээсэн бусад шугам	
67030000	Худалданы санхүүжилтээр дотоодын банкуудад нээсэн шугам	
67040000	Дотоодын банкуудад нээсэн бусад шугам	
67050000	Бусад компанийн, банкны эзэмтэй удирдах хөрөнгө	
67060000	Хэлтэй эзэлжүүлэлтийн орогногч банкинд халаарах эзэл	
67070000	Эрдэнийг илгээж худалдсан эзэл	458,797,613,632.8
67080000	Үүрэг хүлээлгүй баталсан баталганы шугам	
67090000	Үүрэг хүлээлгүй баталсан эзлэлийн шугам	
67100000	Хүлээж авсан дотоодын инкасс	
67110000	Хугацаандаа тологдоогүй дотоодын инкасс	
67120000	Хүлээж авсан гадаргын инкасс	
67130000	Хугацаандаа тологдоогүй гадаргын инкасс	
67140000	Гадаргын явуулсан нэхэмжлэл	
67150000	Гаднаас ирүүлсэн нэхэмжлэл	
67160000	Хадгалсан үнэ бүхий зүйл	14,073.0
67170000	Борлуулалтаар авсан гадаргын чек	
67180000	Борлуулсан үнэт цаас, чек	
67190000	Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, чекийн талвар	91,847.4
67200000	Банкны ажлаар хэрэглэж буй тэмдэгт	9,172.0
67210000	Цэвэр зарг	21,882.0
67220000	Бусад	75,800,050,590.4

Тайланг үзэн зөв гэрэсэн:

Тэргүүн дэд захирал

Дэд захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэнэ


Санхүүгийн газрын захирал

Санхүүгийн газрын бүртгэл, хяналтын мэргэжилтэн

Тайлан мэдээний хэлтсийн захирал

Тайлан мэдээний хэлтсийн хяналтын мэргэжилтэн

Тайлан мэдээний хэлтсийн тайлагчийн мэргэжилтэн



Д.Сугар

Х.Лхагвасүрэн

М.Гантуяа

Ш.Батболтар

Д.Лхагвасүрэн


Д.Наранцаарцаг

Г.Ганбаяр

Handwritten signatures and initials.

хавсралт 3

"Төрийн банк" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн  
19 дугаар тогтоолын хавсралт



## **"ТӨРИЙН БАНК" ХК-ИЙН "НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ"**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1.1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зорилго**

Нягтлан бодох бүртгэл /цаашид "НББ" гэх/-ийн бодлогын баримт бичиг нь Төрийн банк /цаашид "банк" гэх/-ны өдөр тутмын санхүүгийн мэдээллийг данс бүртгэлд тусгах, санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулахад тууштай мөрдөгдөх зүй тогтол болон тогтсон дэг журмыг тодорхойлох, санхүүгийн үнэн зөв тоон мэдээллээр хэрэглэгчдийг хангах зорилготой.

#### **1.2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн тодорхойлолт, түүний үндэс**

1.2.1. НББ-ийн бодлого гэж санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулахад тууштай мөрдөгдөх тухайн банкны баталсан зүй тогтол болон тогтсон дэг журмын суурь юм.

1.2.2. НББ-ийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг ойлгоно.

1.2.3. НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулахад дараах хууль, дүрмийг үндэслэл болгоно. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Банкны тухай хууль,
- Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандарт /цаашид "СТОУС" гэх/,
- Монголбанкны "Нягтлан бодох бүртгэлийн багц материал", түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Бусад хууль, тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар.

1.2.4. Банкны дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журам, зааврын НББ нь энэхүү бодлогод нийцсэн байна.

1.2.5. Бодлогын 1.2.3-т дурьдсан Олон Улсын стандарт болон холбогдох журмууд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд СТОУС-ыг баримтална.

#### **1.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зориулалт**

НББ-ийн бодлогын баримт бичгийг дараах зориулалтаар ашиглана.

- Банкны өдөр тутмын санхүүгийн бүртгэлийг хөтлөх явцад дагаж мөрдөгдөх НББ-ийн зарчмыг тодорхойлох
- Банкны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх
- Гадаад ба дотоод санхүүгийн мэдээлэл хэрэглэгчдийг мэдээллээр хангах

#### **1.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх, түүний хэрэгжилтэд хяналт тавих**

- Энэхүү баримт бичиг нь Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн шийдвэрээр батлагдаж, хүчин төгөлдөр болно.
- НББ-ийн бодлогын баримт бичгийг банкны бүх шатны бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналд дагаж мөрдөнө.
- Дотоод аудит хариуцсан газар, Дотоод хяналт, шалгалт хариуцсан газар, Санхүү хариуцсан газар, Эрсдэлийн удирдлага хариуцсан газар, Бизнесийн бодлого, төлөвлөлт хариуцсан газар тус тус НББ-ийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавина.
- Банкны газар, хэлтэс, алба нэгжийн хяналт тавих үүрэг бүхий ажилтнууд ажлын байрны тодорхойлолтод заагдсаны дагуу шат дараалсан хяналт тавьж ажиллана.
- НББ-ийн ноцтой алдаа гаргасан нь тогтоогдсон бол алдааг илрүүлсэн ажилтан шууд удирдлагад мэдэгдэн холбогдох арга хэмжээг авч ажиллана.
- Дээрх хяналт шалгалтын тайлангийн үр дүн, түүний мөрөөр авсан арга хэмжээг Дотоод аудит хариуцсан газар нь ТУЗ-д, Дотоод хяналт шалгалт хариуцсан газар нь Гүйцэтгэх захиралд, бусад газар Дэд захиралд тайлагнах ба шаардлагатай бол холбогдох хорооны хуралд танилцуулна.

### **ХОЁР. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮНДСЭН ЧАНАР БОЛОН ЗАРЧИМ**

#### **2.1. Санхүүгийн тайлагналын үндсэн чанар болон зарчмууд:**

**“СТОУС-ыг дагаж мөрдөнө”** - Банк нь СТОУС-ыг НББ-ийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

**“Нягтлан бодох бүртгэлийн суурь”** - Банк нь НББ-ийг аккруэл сууриар хөтөлнө. НББ-ийн аккруэл суурь гэж мөнгө хүлээн авсан болон төлсөн эсэхээс үл хамааран орлогыг олсон үед, зардлыг гарсан тухай бүрт нь хүлээн зөвшөөрч бүртгэх арга юм. Аккруэл сууриар гаргасан санхүүгийн тайлан нь өнгөрсөн ажил гүйлгээг мөнгөөр төлсөн буюу авсан үед төдийгүй, ирээдүйд мөнгөөр төлөгдөх өр төлбөр болон ирээдүйд мөнгөөр авах нөөцийн тухай хэрэглэгчдэд мэдээлж, эдийн засгийн шийдвэр гаргахад ач холбогдолтой байдаг.

**“Тасралтгүй байх зарчим”** - Банк нь үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж ирээдүйд оршин тогтноно гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлан бэлтгэнэ.

**“Цэвэр дүн гаргах”** - СТОУС-д шаардсан, зөвшөөрснөөс бусад тохиолдолд хөрөнгө ба өр төлбөр, орлого ба зардлыг нэгтгэж цэвэр дүнгээр тайлагнахгүй.

**“Үнэн зөв толилуулга”** - Банкны санхүүгийн тайлангууд нь санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна. Санхүүгийн тайлангийн тоон болон чанарын үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, шаардлагатай бол нэмэлт тодруулгыг бэлтгэнэ.

**“Иж бүрэн байдал”** - Санхүүгийн тайланд тусгагдах мэдээллийн найдвартай байдлыг хангахын тулд мэдээллийг иж бүрнээр нь тусгана. Мэдээллийг орхигдуулах нь төөрөгдөлд оруулж болзошгүй ба ингэснээр мэдээллийн найдвартай байдал, зохистой чанар алдагдана.



**“Илэрхийллийн тогтвортой байдал”** - Банкны үйл ажиллагаанд гарсан томоохон хэмжээний өөрчлөлтөөс бусад тохиолдолд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн илэрхийлэл болон ангиллыг нэг тайлант үеэс нөгөө тайлант үед өөрчлөхгүй.

**“Санхүүгийн мэдээлэл харьцуулагдахуйц байх”** - Банкны санхүүгийн тайлангийн тоон мэдээлэл нь арга зүйн хувьд бүх тайлант хугацааны адилтгах тоон мэдээлэлтэй харьцуулах боломжтой байна.

**“Цаг хугацаандаа байх зарчим”** - Банкны санхүүгийн тайланг хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөх боломжтой хугацаанд буюу Монголбанкнаас тогтоосон хугацаанд багтаан бэлтгэн, толилуулна.

**“Материаллаг байдал”** - Аливаа зүйлсийг дангаар нь болон хамтад нь орхигдуулснаас болон буруу тайлагнаснаас үүдэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх байдлыг материаллаг байдал гэнэ. Материаллаг байдал нь тухайн нөхцөл байдалд орхигдуулсан болон буруу тайлагнасан зүйлийн мөн чанар, хэмжээнээс шалтгаална. Материаллаг байдлыг тодорхойлогч хүчин зүйл нь тухайн зүйлийн хэмжээ, мөн чанар, тэдгээрийн нэгдэл байж болно.

**“Хэлбэрээс агуулгыг илүүтэй анхаарах”** Аливаа мэдээлэлд ажил гүйлгээ, үйл явдлыг зохих ёсоор тусгахын тулд мэдээллийн агуулга болон эдийн засгийн бодит байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр бүртгэнэ.

## **2.2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн нэгж**

Санхүүгийн тайланг Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлнэ. Гадаад валютаар илэрхийлсэн балансын дансны үлдэгдлийг тухайн өдрийн Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлэн тайлагнах ба валютаар олсон орлого, төлөгдсөн зардлыг тухайн өдрийн Монголбанкны албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэнэ.

**“Бүртгэлийн валют”** гэж банкны үйл ажиллагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчны валют буюу төгрөг юм.

**“Гадаад валют”** гэж төгрөгөөс бусад валютыг хэлнэ.

## **ГУРАВ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ БОДЛОГО**

### **Санхүүгийн тайлангийн зүйлс**

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг хоёр ангилна.

- Санхүүгийн байдлын үзүүлэлтэд хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгө хамрагдана.
- Үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтэд тайлант хугацааны цэвэр ашиг, алдагдлыг хэмжихэд ашиглагдах орлого, зардал хамрагдана.

## **3.1. Санхүүгийн хөрөнгө**

**“Хөрөнгө”** гэж банкны хяналтанд байгаа, өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсч, ирээдүйд эдийн засгийн өгөөж өгөхөөр хүлээгдэж буй нөөц юм.

**“Хөрөнгийг хүлээн зөвшөөрөх”** - Банканд эдийн засгийн ирээдүйн үр ашиг авчрах магадлалтай бөгөөд бодитой хэмжигдэхүйц өртөг буюу үнэ цэнийг агуулж буй тохиолдолд бүх төрлийн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэлд тусгана.

**“Хөрөнгийг данснаас хасах”** - Хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй болсон үед хөрөнгийг данснаас хасна.

Санхүүгийн хөрөнгөд дараах зүйлс орно:

- Мөнгө болон мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө;
- Бусад аж ахуйн нэгжийн өмчийн хэрэглүүр;
- Гэрээний эрх;
- Банкны өөрийн өмчийн хэрэглүүрээр төлбөр тооцоо хийгддэг эсвэл хийгдэх гэрээ.

Банк нь санхүүгийн хөрөнгийг эзэмших зориулалтаар нь дараах байдлаар хэмжиж ангилна:

- Хорогдуулсан өртгөөр,
- Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр /цаашид “ААБҮЦ” гэх/, болон
- Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр /цаашид “ДОБҮЦ” гэх/.

Банк нь хорогдуулсан өртгөөрх болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн хүлээгдэж буй алдагдлын нөөцийг тооцоолж тайлант үе бүрийн эцэст нөөцийг бүртгэнэ.

Банк нь санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн хүлээгдэж буй алдагдлын тооцоололдоо дараах зүйлсийг тусгана:

- Төрөл бүрийн боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жинлэсэн дүн;
- Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ;
- Өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэт их зардал, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээллүүд.

Санхүүгийн хөрөнгийг чанараар нь 3/Stage1, Stage2, Stage3/ ангилна.

Санхүүгийн хөрөнгөд багтах зүйлс:

### **3.1.1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө.**

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь үнэ цэнийн өөрчлөлтөөс өчүүхэн бага эрсдэлийг хүлээдэг бөгөөд үүнд гурав хүртэлх сарын дотор мөнгөнд хөрвөх чадвартай дараах хөрөнгүүд орно.

- Бэлэн мөнгө;
- Монголбанканд байршуулсан төгрөгийн ба гадаад валютын харилцах, хадгаламж;
- Монголбанкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас,
- Урвуу репо /Монголбанк, Засгийн газрын үнэт цаасаар баталгаажсан/;

- Бусад гадаад ба дотоодын банканд байршуулсан төгрөг, валютын харилцах, хадгаламж болон эдгээр хөрөнгүүдэд хуримтлуулан тооцсон хүүгийн авлага зэрэг багтана.

Гурван сараас дээш хугацаатай, хязгаарлагдсан хөрөнгө энэ ангилалд орохгүй.

Хязгаарлагдсан хөрөнгө гэдэг нь хууль эрх зүйн актын хүрээнд тодорхой нөхцлөөр хязгаарлагдсан, банкны зүгээс хөрөнгийг зарцуулах эрх хязгаарлалтай хөрөнгө юм.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг хуримтлуулан тооцсон хүүг нэмсэн дүнгээр санхүүгийн тайланд толилуулна.

Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөд:

- Монголбанканд байршуулсан заавал байлгах нөөц;
- Монголбанк болон бусад гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан гурван сараас дээш хугацаатай хадгаламж;
- Гурван сараас дээш хугацаатай болон гурав хүртэлх сарын хугацаатай Монголбанк, Засгийн газрын үнэт цаасаар баталгаажаагүй урвуу репо үнэт цаас;
- Хамтын зээлжүүлэлт хийх зорилгоор бусад байгууллагад байршуулсан мөнгө;
- Гурван сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан мөнгө зэрэг багтана.

Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийг хуримтлуулан тооцсон хүүг нэмж, эрсдэлийн санг хассан дүнгээр санхүүгийн тайланд толилуулна.

### **3.1.2. Хөрөнгө оруулалт**

Хөрөнгө оруулалтыг шинж чанараас нь хамааруулан өрийн болон өмчийн хэрэглүүр гэж ангилна. Өрийн болон өмчийн хэрэглүүрийг зориулалтаас хамааруулан хорогдуулсан өртгөөр, ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ/ААБҮЦ/-ээр, бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ /БДОБҮЦ/-ээр хэмжих эсэхийг тодорхойлно.

- Хугацааг нь дуустал эзэмших, мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн ба хүүгийн төлөлтөөр илэрхийлэгдэх өрийн хэрэглүүрийг хорогдуулсан өртгөөр хэмжиж бүртгэнэ. Үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан бүртгэнэ.
- Хугацааг нь дуустал эзэмших болон борлуулах зорилгоор эзэмшиж байгаа мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн ба хүүгийн төлөлтөөр илэрхийлэгдэх өрийн хэрэглүүрийг болон борлуулах зорилгогүй эзэмшиж байгаа өмчийн хэрэглүүрийг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэнэ.
- Дээрх хоёр ангилалд хамаарахгүй ашиг олох зорилготой өрийн болон, өмчийн хэрэглүүрийг ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэнэ.

Хөрөнгө, оруулалтыг санхүүгийн тайланд хуримтлуулан тооцсон хүүг нэмж, эрсдэлийн санг хассан дүнгээр санхүүгийн тайланд толилуулна.

### **3.1.3. Зээл**

Зээлийг хөрөнгийн удирдлагын бизнес загвараас нь хамаарч бүртгэх бөгөөд ихэнхдээ хорогдуулсан өртгөөр хэмжиж бүртгэнэ. Худалдах зорилготой зээлүүдийг ААБҮЦ-р хэмжиж бүртгэнэ.

Зээлийг зээлийн үлдэгдэл дээр хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг нэмж, хойшлуулан бүртгэсэн шимтгэлийн орлого, эрсдэлийн санг хассан дүнгээр санхүүгийн тайланд толилуулна. Банк зээлийн эрсдэлийн санг “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу тухай бүр байгуулах ба СТОУС-ын дагуу зээл олголтыг хийсэн даруй хүлээгдэж буй эрсдлийн алдагдлыг урьдчилан тооцож бүртгэнэ. СТОУС-ын дагуу тайлант үе бүрийн эцэст зээлийн ангиллыг тодорхойлж эрсдлийн санг үнэлж бүртгэнэ.

#### **3.1.4. Дериватив санхүүгийн хэрэгсэл**

Гадаад валют, үнэт металлын арилжааны своп, форвард, опцион, фьючерс гэрээ, хейджийн хэрэгсэл, нуугдмал дериватив хэлцлээр үүссэн хөрөнгийг оруулна. Деривативыг бодит үнэ цэнээр үнэлж, ААБҮЦ-р хэмжиж бүртгэнэ.

Банк хейджийн үр өгөөж, холбогдох бусад үнэлгээг бодитой тооцох боломжтой гэж үзвэл хейджийн бүртгэл хөтөлнө. Бодитой үнэлгээ хийх боломжгүй нөхцөлд хейджийг бүртгэхгүй.

#### **3.1.5. Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө**

Бусад санхүүгийн хөрөнгөд бусдаас мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авахаар зөвшөөрөгдсөн гэрээний эрхийг хамруулна. Бусад санхүүгийн хөрөнгөд бусдаас авах авлага, банк, салбар хоорондын тооцооны авлага, санхүүгийн хөрөнгийн хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгө болон бусад хөрөнгө хамаарна. Бусад санхүүгийн хөрөнгийг зориулалтаас нь хамааруулан хорогдуулсан өртгөөр, БДОБҮЦ-р, ААБҮЦ-р хэмжиж бүртгэх эсэхийг тодорхойлно.

Бусад санхүүгийн бус хөрөнгөд санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг хангаагүй хөрөнгүүд хамрагдана. Үүнд урьдчилгаа, зах зээлийн хүүгээс доогуур хүүтэйгээр ажилтнуудад олгосон зээлийн урьдчилгаа, бараа материал үнэ бүхий зүйлс, үнэт металл, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн хэлбэртэй өмчлөх бусад хөрөнгө, тайлант үеийн татварын авлага, хойшлогдсон татварын хөрөнгө, бусад санхүүгийн бус хөрөнгө хамрагдана.

Эрсдэлийн санг тооцох хөрөнгийн хувьд дансны үнийг гаргахдаа холбогдох эрсдэлийн санг хассан дүнгээр санхүүгийн тайланд толилуулна.

#### **3.1.6. Үндсэн хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө, зогсоосон үйл ажиллагаа**

Банкны үйл ажиллагаа, удирдлагын зориулалтаар ашиглах үүднээс банкны эзэмшилд байгаа, нэгээс дээш жилээр ашиглагдах барилга байгууламж, компьютер, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил зэрэг биет хөрөнгө үндсэн хөрөнгөнд хамрагдана. Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн үеэс эхлэн хөрөнгийн элэгдлийг тооцоолно. Үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайланд тусгана. Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтаар анхны өртөгөө бүрэн нөхсөн хөрөнгийн хувьд хөрөнгийг данснаас хасах хүртэл нэмж элэгдэл тооцохгүй. Мөн



агуулахад нөөцөлсөн хөрөнгийн хувьд ашиглалтанд тавьж олгох хүртэл элэгдэл тооцохгүй ба зөвхөн үнэ цэнийн бууралтыг үнэлж бүртгэнэ.

Банк хөрөнгийн дансны үнийг үргэлжлүүлэн ашиглах замаар бус нэг жилийн дотор худалдан борлуулж, өртгийг нөхөхөөр шийдвэрлэсэн тохиолдолд хөрөнгийг борлуулах зориулалттай хөрөнгөөр ангилна. Борлуулах зориулалттай хөрөнгийг элэгдүүлэхгүй ба зөвхөн үнэ цэнийн бууралтыг үнэлж бүртгэнэ.

Банк үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг хаах эсвэл худалдан борлуулахаар болсон бол зогсоосон үйл ажиллагаа гэх ба

- Үйл ажиллагааны тусдаа чиглэл/төрөл эсвэл тодорхой газар зүйн бүсэд явуулдаг үйл ажиллагаа;
- Үйл ажиллагааны тусдаа чиглэл/төрөл эсвэл тодорхой газар зүйн бүсэд явуулдаг үйл ажиллагааны хэсэг болсон;
- Компанийн нэгдлийг худалдан авах үед буцааж худалдах зорилгоор авсан охин компани багтана

### **3.1.7. Биет бус хөрөнгө**

Нэгээс дээш жилийн хугацаанд банкны үйл ажиллагаа, удирдлагын зориулалтаар ашиглах, биет шинж чанаргүй программ хангамж, гүдвилл, патент, лиценз, худалдааны тэмдэг ба худалдааны нэр, зохиогчийн эрх, тусгай зөвшөөрөл зэрэг хөрөнгүүд биет бус хөрөнгөнд хамрагдана.

Хуримтлагдсан хорогдол, үнэ цэнийн бууралтаар анхны өртөгөө нөхсөн биет бус хөрөнгийн хувьд хөрөнгийг данснаас хасах хүртэл нэмж хорогдол тооцохгүй.

Биет бус хөрөнгийг санхүүгийн тайланд хуримтлагдсан хорогдол, үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тусгана.

## **3.2. Өр төлбөр**

**“Өр төлбөр”** гэж өнгөрсөн үйл явдлын үр дүнд бий болсон бөгөөд банк бусдад хөрөнгөө шилжүүлэх буюу үйлчилгээ үзүүлэх замаар хөрөнгийг бусдад шилжүүлэхээр хүлээсэн өнөөгийн үүрэг юм.

**“Өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх”** - Хүлээсэн үүргийг биелүүлснээр эдийн засгийн үр ашгийг агуулж буй нөөцийг бусдад шилжүүлэх магадлалтай ба эцсийн тооцоо хийх мөнгөн дүнг бодитой хэмжих боломжтой тохиолдолд өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

**“Өр төлбөрийг данснаас хасах”** - Өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй болсон, банк гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн нөхцөлд өр төлбөрийг данснаас хасна.

### **3.2.1. Харилцах, хадгаламж**

Харилцах, хадгаламжийн данс гэж иргэд байгууллагаас банканд төлбөр тооцоо хийх, хуримтлал үүсгэх зорилгоор гэрээ байгуулан байршуулсан эх үүсвэр юм. Харилцах, хадгаламжийн дансыг санхүүгийн тайланд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийг нэмсэн дүнгээр толилуулна.

### **3.2.2. Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр**

Монголбанк, бусад банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, бусад банк, санхүүгийн байгууллагаас банканд байршуулсан харилцах, хадгаламжийн данс, банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр хамрагдана. Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийг санхүүгийн тайланд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийг нэмсэн дүнгээр толилуулна.

### **3.2.3. Бусад эх үүсвэр**

Тодорхой зориулалт, нөхцөлтэй байршуулсан эх үүсвэр болон төлбөр тооцооны бусад хэрэгслийн эх үүсвэр болгон ашиглахаар байршуулсан төслийн зээлийн эх үүсвэр, банкнаас гаргасан өрийн бичиг, үнэт цаас, репо үнэт цаас, аккредитив, баталгаа, хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр, түрээсийн өр төлбөр хамрагдана. Бусад эх үүсвэрийг санхүүгийн тайланд эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөгийг нэмсэн дүнгээр толилуулна.

### **3.2.4. Бусад санхүүгийн ба санхүүгийн бус өр төлбөр**

Санхүүгийн өр төлбөр гэж бусад этгээдэд мөнгө ба бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхээр гэрээгээр хүлээсэн үүргийг ойлгоно. Санхүүгийн өр төлбөрт дансны өглөг, банкны дотоод ажил гүйлгээгээр гарах тооцооны өглөг, банк хоорондын төлбөр тооцоо, салбар хоорондын тооцооны өглөг, ногдол ашгийн өглөг, давуу эрхийн хувьцааны өр төлбөр болох хэсэг, хоёрдогч өглөг, бусад өглөгийг хамруулна.

Санхүүгийн бус өр төлбөр гэж санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй цалингийн өглөг, татварын өглөг, өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн Нийгмийн хөгжлийн сан, болзошгүй өр төлбөр, зээлтэй холбоотойгоор хүлээсэн үүрэгт байгуулсан нөөц, мөнгөөр төлөгдөх хувьцааны опцион, хойшлогдсон орлогууд багтана.

## **3.3. Өөрийн хөрөнгө**

**“Өөрийн хөрөнгө”** гэж эзэмшигчдээс оруулсан хөрөнгө оруулалт, түүнийг нэмэгдүүлж буй үйл ажиллагааны үр дүнд бий болсон хуримтлагдсан ашиг, алдагдал зэрэг орох бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон олсон хөрөнгийн нийлбэр буюу нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийг хассаны дараах дүн юм.

**“Өөрийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх”** – оруулсан хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгийг ирээдүйд эдийн засгийн үр өгөөж гадагшлах магадлалтай, өртөгийг бодитой тооцох боломжтой тохиолдолд өөрийн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгана.

### **3.3.1. Хувь нийлүүлсэн хөрөнгө**

**“Энгийн хувьцаа”** гэж эзэмшиж байгаа хувьцааны эзлэх хувь хэмжээгээр хувь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй, банкнаас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй, хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу олгох ногдол ашиг, компанийг татан буулгах үеийн хөрөнгө хуваарилалтаас давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн дараа ногдол ашиг, хөрөнгө хүртэх эрхтэй өмчийн үнэт цаас юм.

**“Давуу эрхийн хувьцаа”** гэж ногдол ашиг, компанийг татан буулгалтын үед ногдол ашиг, хөрөнгийг тэргүүн ээлжинд хүртэх эрхтэй, Монгол Улсын хууль, банкны дүрэмд заасан саналын эрхийн хувиар, зөвхөн дүрмэнд заасан асуудлаар, хувь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй оролцох, удирдлагын шийдвэрээр энгийн хувьцаанд хөрвөх боломжтой өмчийн үнэт цаас юм. Давуу эрхийн хувьцааны гэрээний банк ойрын хугацаанд эргүүлэн авах эсэхийг харгалзан өр төлбөр болон өөрийн хөрөнгөөр бүртгэнэ.

Банкны дүрмийн санг бүрдүүлж буй давуу эрхийн хувьцаа, энгийн хувьцааг нэрлэсэн үнээр бүртгэж, санхүүгийн тайланд толилуулна.

Хувьцааг нэрлэсэн үнээс доогуур үнээр борлуулахгүй.

### **3.3.2. Нэмж төлөгдсөн капитал**

**“Нэмж төлөгдсөн капитал”** гэж хувьцааны нэрлэсэн үнэ болон борлуулсан үнийн зөрүүг хэлнэ.

Нэмж төлөгдсөн капиталыг хувьцааны төрлүүдээр ангилж, бүртгэнэ. Үнэт цаас гаргахтай шууд холбоотой гарсан зардлуудыг Нэмж төлөгдсөн капитал дансыг бууруулж бүртгэнэ.

### **3.3.3. Халаасны хувьцаа**

**“Халаасны хувьцаа”** гэж банк нь өөрийн эргэлтэн дэх хувьцааг буцаан худалдан авсан тохиолдолд энгийн хувьцааны сөрөг тохируулах данс болох “Халаасны хувьцаа” дансанд бүртгэнэ. Халаасны хувьцаа нь ямар нэгэн саналын эрхгүй, ногдол ашиг авах эрхгүй байна.

### **3.3.4. Дахин үнэлгээний нэмэгдэл**

Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнг ТУЗ-ийн хуралд танилцуулан гүйлгээ хийх зөвшөөрлийг авна.

Дахин үнэлгээний загвараар бүртгэдэг үндсэн хөрөнгийг дахин үнэлэхэд үнэ цэн өссөн бол өсөлтийг бүртгэнэ. Хөрөнгийн дахин үнэлгээгээр нэмэгдэл бүртгэгдсэн хөрөнгийг ашиглалтаас хасах буюу данснаас хасах үед тухайн хөрөнгийн өмнө бүртгэгдсэн дахин үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэнд тооцож, хуримтлагдсан ашгийн дансанд шууд шилжүүлэн бүртгэнэ.

### **3.3.5. Хуримтлагдсан ашиг, алдагдал**

**“Хуримтлагдсан ашиг/алдагдал”** гэж банк байгуулагдсанаас хойш олсон хөрөнгийн хуваарилаагүй үлдсэн тайлант үеийн болон өмнөх үеийн ашиг/алдагдал юм. Тайлант үеийн орлого, зардлын дансны цэвэр үлдэгдлээр тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал тодорхойлогдох ба уг дансны үлдэгдлийг хуримтлагдсан ашиг дансанд хаана. Банкны хуримтлагдсан ашгийн данснаас “Төрийн банкны дүрэм”, “Компанийн тухай хууль”-ийн дагуу ТУЗ-ийн тогтоол, хурлын шийдвэрээр хуваарилалт зарцуулалт хийнэ.

### **3.3.6. Бусад өөрийн хөрөнгө**

Хуримтлагдсан ашгаас тусгай зориулалтаар тусгаарласан Нийгмийн хөгжлийн сан, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах эрсдэлийн сан байгуулах зарцуулах журам”-аар байгуулах эрсдэлийн сан нь СТОУС-ын дагуу байгуулсан сангаас илүү гарсан тохиолдолд зөрүү дүнгээр байгуулах сангууд, борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан, хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний сан, хувьцааны опцион, гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц зэрэг дансд хамрагдана.

### 3.4. Орлого

**“Орлого”** гэж тайлант хугацаанд гарсан эдийн засгийн үр ашгийн өсөлтийг хэлэх бөгөөд өөрийн хөрөнгө болон эзэмшигчийн оруулснаас бусад хэлбэрээр өмчийг нэмэгдүүлэхэд хүргэсэн хөрөнгийн өсөлт, өр төлбөрийн бууралтын дүн юм. Банк орлогыг хүлээн авсан буюу хүлээн авахаар хүлээгдэж буй мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр хэмжиж, тайлагнана.

**“Орлогыг хүлээн зөвшөөрөх”** - Орлогын дүнг бодитой тооцох боломжтой, ажил гүйлгээний эцсийн өгөөжийг банк хүртэх магадлалтай тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө.

Орлогод хамрагдах зүйлс:

- Хүүгийн орлого;
- Бусад орлого;
  - Хүүгийн бус орлого
  - Бусад орлого, олз.

**“Хүүгийн орлого”** гэж тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, үнэт цаасны хүүгийн орлого, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө тэдгээрийг ашиглуулсны төлөө авч байгаа төлбөр юм.

**“Хүүгийн бус орлого”** гэж харилцагчдаас авсан банкны бүтээгдэхүүн үйлчилгээний шимтгэл, хураамж, арилжаа болон ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлогууд хамаарна.

**“Бусад орлого, олз”** гэж банкны эрхлэх үндсэн үйл ажиллагаатай холбоогүй ажил гүйлгээнээс үүссэн орлогыг тус тус ойлгоно.

Мөн орлогыг агуулгаас хамааруулан үндсэн үйл ажиллагааны орлого ба бусад орлого, олз гэж ангилна. Үндсэн үйл ажиллагааны орлогод банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн дагуу эрхэлж буй үйл ажиллагаатай холбоотой орлогыг, бусад орлого, олзод банкны бусад үйл ажиллагаанаас үүссэн орлогыг тус тус ойлгоно.

### 3.5. Зардал

**“Зардал”** гэж банкны үйл ажиллагааны явцад тайлант хугацаанд бий болсон Хувь нийлүүлэгчдэд олгосон хуваарилалттай холбоогүй, өмчийг буурахад хүргэж буй хөрөнгийн зарцуулалт болон өр төлбөрийг нэмэгдүүлэх хэлбэрээр гарсан эдийн засгийн үр ашгийн бууралт юм. Зардал нь эдийн засгийн ирээдүйн үр ашгийг бий болгохгүй ба энэ үр ашгийг үнэлж болохгүй буюу тайлан тэнцэлд хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх боломжгүй үед зардлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Орлого олохын тулд гарсан зардлыг орлоготой нь уялдуулах зарчмаар хүлээн зөвшөөрч,



бүртгэнэ. Зардлыг төлсөн ба төлөхөөр хүлээгдэж байгаа мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр тооцож бүртгэнэ.

**“Зардлыг хүлээн зөвшөөрөх”** - Зардлын дүнг бодитой тооцох боломжтой, ажил гүйлгээний үр дүнгээр эдийн засгийн өгөөж буурсан нөхцөлд зардлыг хүлээн зөвшөөрнө.

Зардалд хамрагдах зүйлс:

- Хүүгийн зардал;
- Эрсдэлийн сангийн зардал;
- Бусад зардал;
  - Хүүгийн бус зардал
  - Бусад зардал, гарз
- Орлогын албан татварын зардал.

**“Хүүгийн зардал”** гэж банкны үйл ажиллагааны эх үүсвэрт ашиглахын тулд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлбөр буюу өртөг юм.

**“Хүүгийн бус зардал”** гэж банкны үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа хүүгийн зардлаас бусад төрлийн үйлчилгээ, хүү авчирдаггүй банкны бусад үйлчилгээнээс үүдэн гарсан зардал, удирдлагын зардал зэрэг зардлыг хамруулан ойлгоно.

**“Бусад зардал, гарз”** гэж банкны эрхлэх үндсэн үйл ажиллагаатай холбоогүйгээр гарсан ажил гүйлгээнээс үүссэн зардлыг ойлгоно.

**“Эрсдэлийн сангийн зардал”** гэж үнэ цэнэ буурсан хөрөнгөд байгуулсан эрсдэлийн сангийн зардлыг ойлгоно.

**“Орлогын албан татварын зардал”** гэж Монгол Улсын холбогдох татварын хууль тогтоомжийн дагуу Банкны тооцоолж, тайлагнасан, тайлант хугацааны татвар ногдох орлогоос тооцсон татварын зардлыг хэлнэ.

Мөн зардлыг агуулгаас нь хамааруулж үндсэн үйл ажиллагааны болон бусад зардал, гарз гэж ангилна. Үндсэн үйл ажиллагааны зардалд банкны эрхлэх зөвшөөрөл бүхий үйл ажиллагаатай шууд холбоотойгоор гарсан зардлыг бүртгэх ба бусад зардал, гарзад банкны бусад үйл ажиллагаатай холбоотой гарсан зардлыг тус тус ойлгоно.

### **3.6. Балансын гадуурх данс**

**“Балансын гадуурх данс”** гэж зээл, түүнтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой хүлээж болзошгүй үүрэг, барьцаа хөрөнгө, балансаас хассан хөрөнгө, харилцагчдын өмнөөс батлан даасан хөрөнгө, дериватив, барьцаанд тавьсан хөрөнгө зэрэг банкны зарим үйл ажиллагааг бүртгэх данс юм.

**“Хүлээн зөвшөөрөлт”** Балансын дотуурх бүртгэлийг илүү нарийвчлан бүртгэх, балансад бүртгэлтэй байсан зүйлийг балансаас хассан болон балансад бүртгэх боломжгүй зүйлийг цаашид бүртгэх, тайлагнах шаардлагатай болсон үед балансын гадуурх дансыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

#### **3.6.1. Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг**

Зээл, түүнтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэгт банк бусдын өмнөөс хүлээж болзошгүй банкны бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой хүлээх үүрэг орно. Үүнд: харилцагчийн нэрийн өмнөөс банк гуравдагч этгээдэд гаргасан баталгаа, батлан даалт, нээсэн зээлийн шугам, аккредитивыг бүртгэнэ. Эдгээр дансд нь харилцагчийн шаардсаны дагуу банк хөрөнгө гарган өгөх боломжтой гэдгийг харуулна.

### **3.6.2. Барьцаа хөрөнгө**

“Барьцаа хөрөнгө” гэж зээл, түүнтэй адилтгах хөрөнгөтэй холбогдуулан харилцагчаас банканд барьцаа болгон өгсөн хөрөнгийг ойлгоно. Үүнд санхүүгийн хөрөнгө /үнэт цаас/, санхүүгийн бус хөрөнгө /барилга байгууламж, бараа материал гэх мэт/ хамруулан ойлгоно.

### **3.6.3. Балансаас хассан хөрөнгө**

Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу найдваргүй гэж тооцон, Банкны удирдлагын шийдвэрээр балансаас хассан хөрөнгө, хугацаа хэтэрсэн зээлийн хүүг балансаас хасч, балансын гадуур хуримтлуулж тооцож байгаа хүү, шүүхэд шилжүүлэн хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн хүүг бүртгэнэ. Үүнд: үнэт цаасны эрсдэлийн сангаас хаасан үнэт цаас, зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээл, өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сангаас хаасан хөрөнгө, авлагын эрсдэлийн сангаас хаасан авлага, үнэт металл эрсдэлийн сангаас хаасан хөрөнгө, балансын дотуурх хуримтлуулж тооцохыг зогсоосон хүү хамрагдана.

### **3.6.4. Дериватив санхүүгийн хэрэгсэл**

Валютын зах болон хөрөнгийн зах дээр гадаад валют, үнэт металл, үнэт цаас зэрэг аливаа актив хөрөнгийг арилжихаар хийгдэж байгаа спот, своп, форвард, хейджийн хэрэгсэл, опцион болон бусад гэрээ хэлцлүүдийн гэрээнд заасан үнийн дүнгээр балансын гадуурх холбогдох дансанд бүртгэнэ.

### **3.6.5. Харилцагчийн өмнөөс батлан даасан хөрөнгө**

Банкнаас үзүүлэх үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээ /кастодиан/, хөрөнгө оруулалтын сангийн үйлчилгээ, бусад үйлчилгээг хамруулна.

Банкнаас үзүүлэх үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээ буюу кастодиан банк нь харилцагчийн үнэт цаасыг хадгалах, үнэт цаас өмчлөхтэй холбоотой бусад эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээ бөгөөд Банк “Кастодиан тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын дагуу энэ үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан тохиолдолд балансын гадуур бүртгэнэ.

### **3.6.6. Барьцаанд тавьсан хөрөнгө**

Татан төвлөрүүлсэн санхүүжилтийн эх үүсвэрийн барьцаанд тавьсан хөрөнгийг хамруулна. Үүнд: барьцаанд тавьсан өөрийн хөрөнгө болох үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас, үнэт металл зэрэг хөрөнгүүд багтана.

### **3.6.7. Бусад**

Банкнаас гадаад дотоодын банканд худалдааны санхүүжилт болон төлбөр тооцоог түргэн шуурхай хийх зорилгоор нээсэн шугам, бусад компани Банкны өмнөөс удирдах хөрөнгө, эрсдэлийг үлдээсэн болон шилжүүлж худалдсан хөрөнгө, үүрэг хүлээлгүй баталсан зээл болон баталгааны шугам, хүлээж авсан болон хугацаандаа төлөгдөөгүй гадаад, дотоодын инкасс, гадагш явуулсан болон гаднаас ирүүлсэн нэхэмжлэх, хадгалсан үнэ бүхий зүйл, борлуулахаар авсан гадаадын чек, борлуулсан үнэт цаасны чек, мөнгөн тэмдэгт, үнэт цаас, чекийн загвар, банкны ажилд хэрэглэгдэж байгаа мөнгөн тэмдэгт, цахим карт болон бусад зүйлсийг хамруулан ойлгоно.

### **3.7. Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах**

Төрийн банк нь Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон СТОУС-д нийцүүлэн хөрөнгө оруулалт, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, зээл, бусад санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгийн дансдад эрсдэлийн сан байгуулах журмыг тусад нь боловсруулан мөрдөж ажиллана.

## **ДӨРӨВ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ**

Төрийн банк нь баталсан НББ-ийн бодлогыг тууштай, тогтвортой мөрдөж ажиллана. Төрийн банкны НББ-ийн бодлогын баримт бичгийг СТОУС-д заасны дагуу дараах нөхцөлүүдэд өөрчилнө.

- Монгол Улсын хууль тогтоомжоор шаардсан
- СТОУС шинэчлэгдсэн болон шинэ стандартыг мөрдөж эхлэх хугацаа болсон
- Өөрчлөх нь тайлагнал болон бүртгэлийг илүү тохиромжтой болгосон

### **4.1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**

НББ-ийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэг зарчмыг нийтээр хүлээн зөвшөөрсөн өөр нэг зарчмаар өөрчлөхийг НББ-ийн бодлогын өөрчлөлт гэж ойлгоно. СТОУС-д өөрөөр заагаагүй бол НББ-ийн бодлогын өөрчлөлтийг Монголбанк хүлээн зөвшөөрсөн тохиолдолд дараах зарчмын дагуу тайлагнана.

- Шинэ зарчмыг хэрэглэснээр санхүүгийн тайланд үзүүлэх хуримтлагдсан нөлөөг анхнаас нь хэрэглэж байсан мэтээр хамгийн эхний тайлант үеэс эхлэн нөхөн тооцоолно.
- Цаашид шинэ зарчмаар санхүүгийн тайланд тусгана.

### **4.2. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт**

НББ-ийн арга зарчмыг өөрчлөхгүйгээр шинэ мэдээлэл, шинэ туршлагын үр дүнд тооцооллыг өөрчлөх, өөрчлөлтийг НББ-ийн тооцооллын өөрчлөлт гэж ойлгоно. Тооцооллын өөрчлөлтийн нөлөөг дараах байдлаар тайлагнана. Үүнд:

- Тооцооллын өөрчлөлт нь зөвхөн тайлангийн хугацаанд нөлөөлөх бол өөрчлөлтийг тайлант үед;
- Тооцооллын өөрчлөлт нь тайлант болон ирээдүйн тайлант үед нөлөөлөх бол хоёуланд нь тайлагнана.

## ТАВ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СИСТЕМ БА ДОТООД ХЯНАЛТ

### 5.1. Нягтлан бодох бүртгэлийн систем, түүний хяналт

#### 5.1.1. Нягтлан бодох бүртгэлийн систем

НББ-ийн систем нь ажил гүйлгээг анхан шатны баримтад үндэслэн зохих дансдад бүртгэх, боловсруулах, хадгалах болон хяналт тавих, мэдээ тайлан бэлтгэх, тайлагнах үйл ажиллагааны цогц юм.

**Ажил гүйлгээг бүртгэх, боловсруулах:** Гүйлгээг анхан шатны баримтад үндэслэн цаг хугацаанд нь, үнэн зөв зохих дансанд нь бүртгэх үйл ажиллагаа. Анхан шатны баримт нь цаасан болон электрон хэлбэртэй байна.

**Өдөр тутмын тайлагнал:** Өдрийн гүйлгээг өндөрлөсний дараа тухайн өдрийн санхүүгийн гүйлгээг ерөнхий дэвтэр хөтөлж үлдэгдэл тэнцэл, тайлан мэдээнүүдийг гаргах.

**Мэдээ, судалгаа хийх:** Суурь бүртгэлийн программ, тайлангийн программаас гарсан тайланг үндэслэн судалгаа хийх, хяналт тавих зорилгоор тайлан, мэдээ боловсруулах үйл ажиллагаа.

**Хадгалалт нууцлал:** Ажил гүйлгээ, тайлан мэдээ, судалгааны баталгаажуулагдсан баримт мэдээллийг цаасан болон электрон хэлбэрээр тодорхой хугацаанд архивлан хадгалах, харилцагчийн болон банкны дотоод мэдээллийн нууцлалыг хангаж ажиллах.

#### 5.1.2. Нягтлан бодох бүртгэлийн хяналт

НББ-ийн хяналт, шалгалт нь бүртгэлийн явц дахь алдаа, зөрчил илрүүлэх, тохируулах, залруулах, алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны цогц юм.

##### 5.1.2.1. Нягтлан бодох бүртгэлийн системийн бүрэлдэхүүн тус бүрт хяналтыг дараах хэлбэрээр тавина.

**Шат дараалсан хяналт, шалгалт** гэж хийгдсэн гүйлгээг албан тушаалын шат дарааллын дагуу хянах үйл ажиллагааг ойлгоно.

**Гурвалсан хяналт, шалгалт** гэж хийгдсэн гүйлгээг албан тушаалын шат дараалал харгалзахгүйгээр хянах үйл ажиллагааг ойлгоно. Гурвалсан хяналтыг их дүнтэй гүйлгээний хувьд хийнэ.

**Тайлангийн хяналт** гэж санхүүгийн тайлан мэдээ авах байдлаар НББ-ийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих үйл ажиллагааг ойлгоно.

**Газар дээрх хяналт** гэж хийгдсэн гүйлгээ ба анхан шатны баримтын бүрдлийг шалгах замаар бүртгэлийн хяналт, шалгалтыг газар дээр очиж хийх үйл ажиллагааг ойлгоно.

##### 5.1.2.2. Нягтлан бодох бүртгэлийн хяналтыг хэрэгжүүлэх системийн элемент тус бүрийн хувьд дараах байдлаар хянана.



#### **5.1.2.2.1. Ажил үйлчилгээний бүртгэл, боловсруулалтын хяналт**

“Ажил гүйлгээний бүртгэл, боловсруулалтын хяналт” гэж дотоодын болон харилцагчийн дансыг нээх, гүйлгээний анхан шатны баримтыг хүлээн авч гүйлгээг зохих дансанд бүртгэх үйл ажиллагаанд тавих хяналтыг ойлгоно. Ажил гүйлгээний хяналт нь дараах төрөлтэй байна. Үүнд:

- Баримтын бүрдлийн хяналт;
- Данс гүйлгээний бүртгэлийн хяналт;
- Программын хяналт;
- Эрсдэлийн хяналт.

“Баримтын бүрдлийн хяналт” гэж “Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”, түүнд нийцүүлэн гаргасан төлбөр тооцооны холбогдох журамд заасны дагуу гүйлгээний болон данс нээх баримтын бүрдлийг хянах үйл ажиллагааг ойлгоно.

“Данс гүйлгээний бүртгэлийн хяналт” гэж дансны мэдээлэл нь батлагдсан дансны төлөвлөгөөний дагуу байгаа эсэх, журналын бичилт нь зөв хийгдсэн эсэхийг хянах үйл ажиллагааг ойлгоно.

“Программын хяналт” гэж банкны хэрэглэж буй суурь бүртгэлийн программын үйлдэл үнэн зөв байгаа эсэх, бүртгэлийн программ нь банкны үндсэн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй бусад программуудтай тохирч, үйлдэл болон үлдэгдэл таарч байгаа эсэхийг хянах үйл ажиллагааг ойлгоно.

“Эрсдэлийн хяналт” гэж тухайн ажил гүйлгээ хийгдснээс учирч болзошгүй эрсдэлийг хянах үүднээс ажил гүйлгээний шинж чанар, харилцагчийн банктай харилцсан түүх болон бусад субъектив хүчин зүйлсийг ажил гүйлгээг хийх явцдаа сайтар анхаарч хянах үйл ажиллагааг хэлнэ.

#### **5.1.2.2.2. Хадгалалт нууцлалын хяналт**

“Нягтлан бодох бүртгэлийн хадгалалтын хяналт” гэж НББ-ийн баримтыг хадгалах үйл ажиллагааны хяналтыг ойлгоно. Энэ нь баримтын хадгалалтын хяналт, электрон хадгалалтын хяналт гэсэн 2 хэсэгтэй байна.

“Баримтын хадгалалтын хяналт” гэж НББ-ийн бүх төрлийн баримтууд, тайлан, мэдээ, судалгааны материалуудыг банкны холбогдох журам, зааварт заасны дагуу хадгалах үйл ажиллагаанд хяналт тавихыг ойлгоно.

“Электрон хадгалалтын хяналт” гэж НББ-ийн гүйлгээ, холбогдох тайлан мэдээ, судалгааны материалуудыг банкны холбогдох

электрон архивын журамд заасны дагуу хадгалалтад хяналт тавихыг ойлгоно.

**“Нягтлан бодох бүртгэлийн нууцлалын хяналт”** гэж харилцагчийн болон банкны дотоод мэдээллийн нууцлалыг банкны холбогдох нууцын журамд заасны дагуу хадгалагдсан эсэхэд тавих хяналтыг ойлгоно.

#### 5.1.2.2.3. Тайлангийн хяналт

**“Тайлангийн хяналт”** гэж санхүүгийн тайлан цаг хугацаандаа үнэн зөв гарсан эсэхэд тавих хяналтыг ойлгоно.

### 5.2. Нягтлан бодох бүртгэлийн системд оролцогчид, тэдгээрийн үүрэг

НББ-ийн системд дараах үндсэн чиг үүрэгтэй субъектүүд оролцоно.

**Нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээг хэрэгжүүлэгч:** гэж харилцагчийн болон дотоодын дансдтай холбогдолтой бүх мэдээллийг программд үнэн зөв оруулах, санхүүгийн гүйлгээг үнэн зөв бүртгэх үүрэгтэй. НББ-ийн ажил гүйлгээг хэрэгжүүлэгчид дараах албан тушаалтнууд хамрагдана. Үүнд:

- Ерөнхий нягтлан бодогч;
- Харилцааны ахлах менежер;
- Харилцааны менежер;
- Нягтлан бодогч;
- Ахлах теллер;
- Теллер, вип теллер, мэргэшсэн теллер;
- Системийн оператор.

**Хамаарах ажил үүргийн хүрээнд гүйлгээ хийх шийдвэр бичигч, баталгаажуулагч:** Өөрийн ажил үүргийн хүрээнд хийгдэх санхүүгийн гүйлгээний шийдвэрийг бичиж, удирдлагаар баталгаажуулна. Шийдвэр бичигч нь дангаар шийдвэр гаргах эрхгүй бөгөөд шат дарааллын дагуу гарын үсэг зурж, баталгаажуулснаар гүйлгээ хийх шийдвэр хүчин төгөлдөр болно.

- Гүйцэтгэх захирал;
- Тэргүүн дэд захирал;
- Дэд захирал;
- Газрын захирал;
- Тухайн ажил үүргийн чиглэлээр шийдвэр гаргах эрх бүхий хэлтсийн захирал, албаны менежер, ажилтан;
- Салбарын захирал;
- Тооцооны төвийн эрхлэгч;
- Харилцааны менежер;
- Ерөнхий нягтлан бодогч;
- Ахлах теллер;

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтэнд ерөнхий хяналт тавигч:** НББ-ийн баримт бичгийг боловсруулж, сайжруулах, бүртгэлийн ерөнхий хяналт тавих үүрэгтэй.

- Дотоод аудит хариуцсан газар;
- Дотоод хяналт, шалгалт хариуцсан газар;

- Санхүү хариуцсан газар;
- Эрсдэлийн удирдлага хариуцсан газар;
- Бизнесийн бодлого, төлөвлөлт хариуцсан газар;

**Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлэгч:** НББ-ийн үйл ажиллагааг хэвийн, найдвартай, тасралтгүй явагдах нөхцөлийг хангах үүрэгтэй.

- Мэдээллийн технологи хариуцсан газар;
- Хүний нөөц хариуцсан газар;
- Салбарын удирдлага хариуцсан газар;
- Хууль хариуцсан газар;
- Аж ахуй, аюулгүй байдал хариуцсан газар;
- Үйл ажиллагаа хариуцсан газар;
- Хөрөнгө зохицуулалт хариуцсан газар;
- Маркетинг олон нийт хариуцсан газар;
- Зээл хариуцсан газар;
- Компаенс хариуцсан газар;
- Харилцагчийн үйлчилгээ хариуцсан газар;
- Даатгал хариуцсан газар;

### **5.3. Нягтлан бодох бүртгэлийн алдаа, хүлээлгэх хариуцлага**

#### **5.3.1. Нягтлан бодох бүртгэлийн алдаа**

Математик тооцоолол, бүртгэлийн заавар болон бусад холбогдох журам, зааврын хэрэглээний алдаа, баримтыг буруу ашиглаж залилах, хяналт тавиагүй зэрэг шалтгаанаар үүссэн өмнөх болон одоогийн тайлант үеүүдэд гарсан зөрчлийг бүртгэлийн алдаа гэнэ. НББ-ийн алдааг нөлөөлөл, үр дагавраар нь дараах байдлаар ангилна. Үүнд:

##### **5.3.1.1. Балансын алдаа**

- Балансын дүнд нөлөөлөх – Балансын дүнд нөлөөлж балансыг бодитой байх ёстой дүнгээс нь их буюу багаар илэрхийлэхэд хүргэсэн алдаа;
- Балансын дүнд нөлөөлөхгүй – Балансын дүнд нөлөөлөхгүй боловч балансын бүлэг дотроо нэг үзүүлэлтийг өөр үзүүлэлт хэлбэрээр харуулсан алдаа.

##### **5.3.1.2. Орлогын тайлангийн алдаа**

- Нийт ашгийн дүнд нөлөөлөх – Орлого, зардлын дансыг их, багаар буруу бүртгэсэн алдаа;
- Нийт ашгийн дүнд нөлөөлөхгүй ба татвар ногдох орлогод нөлөөлөх – татварын зорилгоор нэмэгдэж, хасагдах орлого, зардлыг буруу илэрхийлсэн алдаа;
- Нийт ашгийн дүнд нөлөөлөхгүй ба татвар ногдох орлогод нөлөөлөхгүй – татвар ногдох орлогод нөлөөлөхгүй боловч орлого, зардлыг өөр зүйл ангиар бүртгэх алдаа.

#### **5.3.2. Нягтлан бодох бүртгэлийн алдааны төрөл**

##### **5.3.2.1. Данс, ажил гүйлгээний бүртгэлтэй холбоотой алдаа**

- Данс бүртгэхдээ бүтээгдэхүүний код, төрлийн код, харилцагч болон дансны сегментийг буруу сонгосон;
- Ажил гүйлгээг буруу дүнгээр бүртгэсэн;
- Харилцагчийн мэдээлэл буруу, дутуу, шаардлага хангахгүй мэдээлэл оруулсан;
- “Төрийн банкны санхүүгийн бүртгэл хөтлөх заавар”, бусад журмыг санаатай болон санамсаргүйгээр баримтлаагүйгээс буруу гүйлгээ хийсэн.

#### **5.3.2.2. Тооцооллын алдаа**

- Програмын тооцооллыг хянаагүй;
- Програмаар тооцдоггүй бусдад төлөх хүүгийн тооцоо, бусдаас авах хүүгийн орлогын тооцоог буруу тооцоолсон;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоо, болзошгүй алдагдлаас хамгаалах сангийн тооцоог буруу тооцоолсон;
- Үнэт цаасны хямдруулалт, урамшууллын хорогдуулалтыг буруу тооцсон.

#### **5.3.2.3. Ажил гүйлгээг цаг хугацаанд нь бүртгээгүй алдаа**

- Хоорондын тооцоо зөрүүлсэн;
- SWIFT-ийн гүйлгээг дотоодын бүртгэлд тухай бүр тусгаагүй;
- Банк хоорондын гүйлгээг тухай бүр оруулаагүй;
- Картын авлага, өглөгийг тухай бүр хаагаагүй;
- Өдрийн эцэст хаагддаг түр дансдыг хаагаагүй;
- Программд тухайн өдрийн албан ханшийг буруу оруулсан;
- Элэгдлийн зардлыг тухайн тайлант хугацаанд бүртгээгүй;
- Орлого, зардлын гүйлгээг тухай бүр хийгээгүй;
- Урьдчилж төлсөн зардлуудыг журмын хугацаанд нь хаагаагүй;

#### **5.3.2.4. Тайлангийн алдаа**

- Тайлан, мэдээг балансаас зөрүүтэй гаргасан;
- Тайлан мэдээний доторх үзүүлэлтүүдийг буруу гаргасан;
- Холбогдох тайлан мэдээг хугацаа хожимдуулсан, олон дахин шаардуулсан;
- Бусад.

### **5.3.3. Нягтлан бодох бүртгэлийн алдаанд хүлээлгэх хариуцлага**

Бүртгэлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан нь авилга, ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй аливаа үйл ажиллагаанаас ангид байна.

НББ-ийн алдаа гаргаж банк болон харилцагчдад хохирол учруулсан, төлбөр тооцоо саатуулсан, хөндлөнгийн аудитаар зөрчилгүйгээс бусад дүгнэлт авсан бол иргэний, захиргааны, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй тохиолдолд гэм буруутай ажилтан, албан тушаалтанд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 348 дугаар тогтоол, Сангийн сайдын 2009 оны 259 дугаар тушаалын дагуу 100 хувь Төрийн өмчит “Төрийн банк”-ийг үүсгэн байгуулахаар шийдвэрлэж, Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 дугаар тушаалаар батлагдсан “Банк түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ыг тус тус үндэслэн 2009 оны арваннэгдүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсанаас хойш өдгөө 13 дахь жилдээ үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн хурлаас Төрийн банкныг “Дундаж давхаргыг дэмжигч банк” болгохоор шийдвэрлэсний дагуу Банк нь Монгол орон даяар 496 салбар нэгжээр дамжуулан, 2,3 сая харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн, байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжихэд чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх зорилгыг эрхэмлэн, дундаж давхаргыг дэмжигч, үндэсний тэргүүлэгч банк болох алсын хараатай ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн чуулганаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Төрийн банк” ХК нь системийн нөлөө бүхий банкнуудаа түүчээлж нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжихээр Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-нд үнэт цаасаа бүртгүүлэн, нийт гаргасан хувьцааныхаа 5.71 хувийг олон нийтэд гаргаснаар 25.4 тэрбум төгрөгийг 7,421 хувьцаа эзэмшигчдээс амжилттай татан төвлөрүүлж, нээлттэй хувьцаат компани болсон.

### **Төлөөлөн удирдах зөвлөл:**

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын 05 дугаар тогтоолоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг олон улсад хэрэгжиж буй засаглалын сайн практик, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д тус тус нийцүүлэн шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Шинэчлэгдэн батлагдсан Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал сар бүр тогтмол, шаардлагатай нөхцөлд тухай бүр хуралдаж, банкны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, гүйцэтгэх удирдлагыг томилох, гэрээ сунгах, банкны дунд хугацааны стратегийг батлах, зохистой засаглалын

болон эрсдэлийн удирдлагын бодлого, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлттэй танилцах, батлах, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрийг хэрэгжилтийг хангуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж үүрэг даалгавар чиглэл өгч ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл 2024 оны эхний хагас жилд ээлжит болон ээлжит бусаар нийт 9 удаа хуралдан, 38 тогтоол, 9 шийдвэр тус тус гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын ирц тогтмол 88.6%-иас дээш хувьтай хуралдсан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж, тогтоолын биелэлтийг Гүйцэтгэх удирдлага болон Дотоод аудитын газраас гаргуулан нэгтгэж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан, хяналт тавин ажиллаж байна.

Түүнчлэн, Банкны тухай хууль, Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр зарлан хуралдуулж “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай асуудлыг хэлэлцэн, Хувьцаа эзэмшигчдэд “Төрийн банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, “Төрийн банк” ХК-ийн ногдол ашиг хуваарилалтын тайлан, “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай асуудлыг тус тус танилцуулсан байна.

#### **ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл:**

##### **ТУЗ-ийн дарга:**

- Б.Тэлмүүн - Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга. МУИС-ийн Олон улсын харилцааны сургуульд олон улсын эдийн засгийн харилцаа бакалавр, СЭЗДС-д Санхүүгийн удирдлагын бакалавр, МУИС-ийн Хууль зүйн сургуульд олон улсын эрх зүйн магистр, АНУ-ын Корнеллийн Их сургуульд эдийн засаг, санхүүгийн бодлогын чиглэлээр нийтийн удирдлагын магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 2010-2022 онд Сангийн яаманд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт мэргэжилтэн, хэлтсийн дарга, газрын дарга, Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлийн гишүүн, даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай.

##### **Гишүүд:**

- Б.Ганбат - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга. ЗХУ-ын Дотоод явдлын яамны Академийн хууль эрх зүй бакалавр, ИБУИНВУ-ын Коммонвелт хуулийн коллежид Хууль эрх зүйн магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 1995-2016 онд Сангийн яаманд хуулийн зөвлөх, мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, Сайдын зөвлөлийн нарийн бичгийн дарга, газрын орлогч дарга, газрын дарга, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт газрын дарга, Тэргүүн дэд даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат хуульч.

- Б.Сүх-Очир – Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга. МУИС-д эдийн засгийн математик загварчлалын бакалавр, Австралийн Холбооны Улсын Сиднейн их сургуулийн эдийн засгийн онолын магистрын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 2005-2022 онд Сангийн яамны Төрийн сангийн газар, Дотоод аудит, хяналт шинжилгээ,

үнэлгээний газарт мэргэжилтэн, хэлтсийн дарга, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, тус газрын даргаар тус тус ажилласан туршлагатай.

- Г.Золбоо – Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга. МУИС–ийн Эдийн засгийн сургуулийн банкны эдийн засагч бакалавр, ИБУИНВУ–ын Уельсийн их сургуулийн олон улсын бизнесийн менежментийн чиглэлээр боловсрол эзэмшсэн. 2013-2022 оны хооронд Сангийн яаманд зөвлөх, хэлтсийн дарга, газрын даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай.

- Л.Соноор – Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга. АНУ-ын Такома коммюнити коллежийн Бизнесийн удирдлага, АНУ-ын Вашингтоны их сургуулийн Санхүү, бизнесийн удирдлагын бакалавр зэргээр боловсрол эзэмшсэн. 2015-2022 онд Сангийн яаманд Санхүүгийн бодлогын газарт зөвлөх, мэргэжилтэн, хэлтсийн даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай.

- Д.Цолмон - Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хууль, эрх зүйч бакалавр, АНУ-ын Калифорнийн Беркли их сургуулийн Хуулийн сургуулийн хууль эрх зүйч магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 2010-2022 онд хуулийн фирмд хуульч, ахлах хуульч, Ерөнхийлөгчийн тамгын газарт Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөхийн туслах, Хууль зүй, дотоод хэргийн яаманд Сайдын зөвлөхийн туслах, мэргэжилтэн, шинжээч, газрын даргаар тус тус ажилласан ажлын туршлагатай.

- Хараат бус гишүүн М.Батжаргал - Хөдөө аж ахуйн дээд сургуулийг эдийн засагч бакалавр, эдийн засгийн ухааны магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 1975-1989 онд Улсын банканд эдийн засагч, орлогч дарга, Увс аймгийн Арбитр - Ерөнхий арбитрч, 1993-2008 онд Монголбанканд газрын захирал, ерөнхий захирал, ахлах ажилтан, ахлах хянан шалгагч, Хяналт шалгалтын хэлтсийн захирал, Дотоод аудитын газрын ахлах хянан шалгагч, аудитын зөвлөхөөр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.

- Хараат бус гишүүн Д.Энхжаргал - ОХУ-ын Эрхүүгийн улс Ардын аж ахуйн дээд сургуулийн Санхүү банкны эдийн засагч бакалавр, АНУ-ын Вандербилдын их сургуулийн Эдийн засгийн хөгжлийн магистр, ИБУИНВУ-ын Сити их сургуулийн судлаач докторант, Лондонгийн их сургуулийн судлаач докторантын зэргээр тус тус боловсрол эзэмшсэн. 1986-1991 онд Улсын банкны Ерөнхий хороонд зээлийн эдийн засагч, 1991-2015 онд Монголбанканд эдийн засагч, газрын захирал, Ерөнхий эдийн засагч, Ерөнхийлөгчийн зөвлөх, Дэд ерөнхийлөгч, Лондон дахь Монголбанкны Төлөөлөгчийн газрын захирал, Санхүүгийн хөгжлийн стратегийн зөвлөхөөр тус тус ажилласан ажлын туршлагатай. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн,

- Хараат бус гишүүн С.Цэнд-Аюуш – Санхүүч, ОХУ-ын Эрхүү хотын Улс Ардын Аж Ахуйн дээд сургуульд санхүүч бакалаврын зэргээр боловсрол эзэмшсэн. 1978-2015 онд Сангийн яаманд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар мэргэжилтэн, ахлах мэргэжилтнээр тус тус ажилласан ажлын туршлагатай. Монгол Улсын гавьяат эдийн засагч.

Тус банкны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу ТУЗ нь хараат бус 4, ердийн 5 буюу нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар шинэчлэн тогтоосон бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс 5 дугаар сарын 13-ны өдрийн хооронд зохион байгуулж, ТУЗ-ийн хараат бус гишүүнд хууль тогтоомжийн дагуу тавигдсан шаардлага хангасан 5 нэр дэвшигч болон төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх ТУЗ-ийн 5 ердийн гишүүнд холбогдох материалыг

Монголбанканд хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэхэд шаардлагатай холбогдох зөвшөөрлийг авахаар хүргүүлсэн.

Тус сонгон шалгаруулалтын үр дүнд ТУЗ-ийн хараат бус гишүүнд 2 эмэгтэй, 3 эрэгтэйг, ТУЗ-ийн ердийн гишүүнд 1 эмэгтэй, 4 эрэгтэйг санал болгоод байна.

#### **Гүйцэтгэх захирал:**

• Ө.Гантөр - Төрийн банкны Гүйцэтгэх захирал. СЭЗДС-ийг Банк санхүүч, бакалавр, KDI School of PPM Korea сургуулийг Удирдлагын ухааны магистрын зэргээр боловсрол эзэмшсэн. 1996-1997 онд “Монком” ХХК-д Нягтлан бодогч, 1997-1999 онд “ММ Инвест” банканд эдийн засагч, 1999-2011 онд Монголбанканд Хянан шалгагч, Ахлах хянан шалгагч, 2011-2013 онд Төрийн банканд Дэд захирал, 2013-2018 онд Монголбанканд Ахлах хянан шалгагч, 2018-2019 онд Төрийн банканд Байгууллагын банкны газрын захирал, 2019-2020 онд Төрийн банканд Тэргүүн дэд захирлаар тус тус ажилласан ажлын туршлагатай.

#### **Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод:**

Тус банкны ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд ТУЗ-ийн 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 11 дүгээр тогтоолын дагуу өөрчлөлт оруулсан.

#### **Аудитын хороо**

Хорооны дарга:	С.Цэнд-Аюуш	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүд:	М.Батжаргал Л.Сонор	ТУЗ-ийн хараат бус гишүүн ТУЗ-ийн гишүүн

#### **Эрсдэлийн удирдлагын хороо**

Хорооны дарга:	Г.Золбоо	ТУЗ-ийн гишүүн
Гишүүд:	С.Цэнд-Аюуш Д.Энхжаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн ТУЗ-ийн хараат бус гишүүн

#### **Нэр дэвшүүлэх хороо**

Хорооны дарга:	Д.Энхжаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүд:	М.Батжаргал Б.Тэлмүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн ТУЗ-ийн дарга

#### **Цалин урамшууллын хороо**

Хорооны дарга:	М.Батжаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Гишүүд:	С.Цэнд-Аюуш Б.Ганбат	ТУЗ-ийн хараат бус гишүүн ТУЗ-ийн гишүүн

#### **Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга:**

“Төрийн банк” ХК-ийн дүрэмд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглалын албаны ажиллах журам” батлагдаж, тус албыг Төлөөлөн

удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга ахлан ажиллаж, Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглалын алба нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, “Төрийн банк” ХК-ийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”, Монголбанкнаас баталсан “Банкны зохистой засаглалын журам”-ын хэрэгжилтийг хангуулах, банкны зохистой засаглалын бодлогыг хэрэгжүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны зохион байгуулалт, банкны үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангуулах, холбогдох тайлан, мэдээг цаг тухай бүр нь эрх бүхий байгууллагад хүргүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороодын хурлыг зохион байгуулж, хурлаар хэлэлцэх асуудлын хууль зүйн үндэслэл, холбогдох бусад эрх зүйн хэм хэмжээний нийцэл зэргийг хянан, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдээр хянуулан баталгаажуулж, тогтоолын биелэлтийг Гүйцэтгэх удирдлага болон Дотоод аудитын газраас гаргуулан нэгтгэж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж ажилласан.

Мөн Засаглалын алба нь Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурлаар батлах дүрэм, бодлого, журмын төслийг Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-д нийцүүлэн боловсруулж холбогдох хурлаар хэлэлцүүлэн батлуулж ажиллалаа.

Мэдээлэл бэлтгэсэн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



/Э.Уянга/



